

“Лайфтайм инвестмент” ХХК-д брокер, дилер,  
андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалтууд болон “Лайфтайм инвестмент” ХХК-иас 2008 оны 02 дугаар сарын 04-ний өдөр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Лайфтайм инвестмент” ХХК-д үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгосугай.

2.Брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосонтой холбогдуулан зохих баримт бичгүүдэд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэн ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Лайфтайм инвестмент” ХХК /Ж.Цэдэнрагчаа/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ